


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэл Монгол улс дэлхийн 145 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт **12,109.6** сая ам.доллар болж 2024 оны мөн үеэс 1,155.0 сая ам.доллар буюу 8.7 хувиар буурчээ.

Экспортын дүн импортын дүнгээс 1,053.2 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 6 сар				Өөрчлөлт	
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	9,257.1	11,838.1	13,264.6	12,109.6	-1,155.0	-8.7
-Экспорт	5,309.1	7,564.4	7,886.2	6,581.4	-1,304.8	-16.5
-Импорт	3,948.0	4,273.6	5,378.4	5,528.2	149.8	2.8
Тэнцэл	1,361.1	3,290.8	2,507.8	1,053.2	-1,454.6	-58.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **1,053.2** сая ам.долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 1,454.6 сая ам.доллараар буурахад импортын өсөлт экспортын өсөлтийг давсан нь нөлөөлсөн байна.

Экспорт: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **6,581.4** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,304.8 сая ам.доллар буюу **16.5 хувиар буурсан** байна.

Импорт: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр импорт **5,528.2** сая ам.долларт хүрч, 2024 оны мөн үетэй харьцуулахад 149.8 сая ам.доллар буюу **2.8 хувиар өссөн** байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Монгол Улс дэлхийн 67 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 91.6 хувь, Швейцарт 5.2 хувь, АНУ-д 1.2 хувь тус тус ногдож нийт экспортын 98.0 хувийг дээрх орнууд эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **5,813.6** сая ам.доллар болж, өмнөх оноос 1,202.6 сая ам.доллар буюу 17.1 хувиар буурсан

бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **767.8** сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 102.2 сая ам.доллар буюу 11.7 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспортын эдийн засагт эзлэх хувь өндөр байгаа тул экспортын орлогын бууралт нь манай улсын эдийн засгийн өсөлт болон төсвийн орлогод сөрөг нөлөөг үзүүлсэн хэвээр байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 6 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	4,437.1	6,595.3	7,016.2	5,813.6	-1,202.6	-17.1	88.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	871.2	969.2	870.0	767.8	-102.2	-11.7	11.7
Нийт экспорт	5,308.3	7,564.4	7,886.2	6,581.4	-1,304.8	-16.5	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 38.9 хувийг нүүрс, 35.7 хувийг зэсийн баяжмал, 6.3 хувийг боловсруулаагүй алт, 4.2 хувийг төмрийн

хүдэр, 2.3 хувийг жоншны баяжмал, 2.0 хувийг боловсруулаагүй нефть тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 6 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	785.2	1,053.6	268.5	34.2
Нүүрс	сая.тн	40.6	37.9	-2.7	-6.8
Төмрийн хүдэр	сая.тн	3.6	3.9	0.3	7.2
Цайрын баяжмал	мян.тн	62.1	74.6	12.5	20.1
Алт	тн	5.0	4.2	-0.9	-17.4
Түүхий нефть болон газрын тос	сая.баррель	2.1	1.8	-0.3	-13.5
Катодын зэс	мян.тн	6.1	7.4	1.3	21.0
Жоншны баяжмал	мян.тн	583.8	797.3	213.6	36.6
Адууны мах	мян.тн	5.0	7.9	2.9	58.7
Өлөн гэдэс	тн	323.3	624.3	301.0	93.1
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	21.2	0.5	-20.7	-97.7
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	185.8	27.2	-158.6	-85.4
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	0.4	1.4	0.9	234.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	30.8	10.8	-20.0	-64.9
Ямааны самнасан ноолуур	тн	278.5	452.0	173.5	62.3
Ямааны угаасан ноолуур	мян.тн	2.7	-	-2.7	-100.0
Самнаагүй хонины ноос	мян.тн	1.9	1.2	-0.7	-38.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний 6 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2024	2025	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	1,454.4	2,352.3	897.9	61.7	35.7
Нүүрс	4,675.4	2,557.0	-2,118.4	-45.3	38.9
Төмрийн хүдэр	292.5	275.8	-16.7	-5.7	4.2
Цайрын баяжмал	85.4	114.1	28.7	33.6	1.7
Алт	356.0	411.9	55.9	15.7	6.3
Түүхий нефть болон газрын тос	165.8	134.4	-31.4	-19.0	2.0
Катодын зэс	52.5	67.1	14.5	27.7	1.0
Жоншны баяжмал	130.3	153.1	22.8	17.5	2.3
Адууны мах	17.6	28.0	10.4	59.4	0.4
Өлөн гэдэс	6.3	7.9	1.6	25.3	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.4	0.01	-0.4	-97.6	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.5	0.02	-0.4	-95.3	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.00	0.03	0.0	558.5	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.8	0.2	-0.6	-74.3	0.0
Ямааны самнасан ноолуур	28.4	42.3	13.9	48.8	0.6
Ямааны угаасан ноолуур	146.3	-	-146.3	-100.0	0.0
Самнаагүй хонины ноос	2.1	1.3	-0.8	-37.7	0.0
Нийт экспортод эзлэх хувь	94.0	93.4	-0.6	-0.7	93.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Гол нэр төрлийн эсспортын бүтээгдэхүүний үнэ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 6 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	118.5	72.9	-45.6	-38.5
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,852.4	2,232.5	380.2	20.5
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	81.3	71.5	-9.8	-12.1
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,376.6	1,530.6	153.9	11.2
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	223.2	192.0	-31.2	-14.0
Молибдены баяжмал	тн/ам.дол	15,173.0	15,923.5	750.5	4.9
Алт	кг/ ам.дол	70,519.2	98,810.5	28,291.3	40.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **2,557.0** сая ам.долларын **37.9** сая.тн нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 2,118.4 (45.3%) сая ам.доллар, биет хэмжээ 2.7 (6.8%) сая.тн-оор тус тус буурсан. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ **72.9** ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс **38.5** хувиар буурчээ.

Зэсийн баяжмал: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **2,352.3** сая ам.долларын **1,053.6** мян.тн зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 897.9 (61.7%) сая ам.доллар, биет хэмжээ 268.5 (34.2%) мян.тн-оор тус тус өссөн. Нэг тонн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ **2,232.5** ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 20.5 хувиар өсжээ.

Төмрийн хүдэр, баяжмал: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **275.8** сая ам.долларын **3.9** сая.тн төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 16.7 (5.7%) сая ам.доллараар буурч, биет хэмжээ 0.3 (7.2%) сая.тн-оор өссөн. Нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ **71.5** ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс **12.1** хувиар буурчээ.

Жоншны хүдэр, баяжмал: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **153.1** сая ам.долларын **797.3** мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмалын 87.3 хувийг БНХАУ, 12.2 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 22.8 (17.5%) сая ам.доллар, биет хэмжээ 213.6 (36.6%) мян.тн-оор тус тус өссөн байна. Нэг тонн жоншны хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ **192.0** ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 14.0 хувиар буурчээ.

Цайрын баяжмал: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **114.1** сая ам.долларын **74.6** мян.тн цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолжээ. Цайрын баяжмал нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 28.7 (33.6%) сая ам.доллар, биет хэмжээ 12.5 (20.1%) мян.тн-оор тус тус өссөн. Нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ **1,530.6** ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 11.2 хувиар өсчээ.

Алт: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **411.9** сая ам.долларын **4.2** тонн алтны 82.6 хувийг Швейцар, 16.6 хувийг АНУ руу тус тус экспортолжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 55.9 (15.7%) сая ам.доллараар өсөж, биет хэмжээ 0.9 (17.4%) тн-оор буурсан. Нэг килограмм алтны экспортын дундаж үнэ **98,810.5** ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **40.1** хувиар өссөн байна.

Газрын тос: 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 134.4 сая ам.долларын 1.8 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 31.4 (19.0%) сая ам.доллар, биет хэмжээ 0.3 (13.5%) сая.бар-иар тус тус буурчээ. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Нүүрс, зэсийн баяжмал, алт, цайрын баяжмалын экспортын биет хэмжээ болон орлого нь экспортын бүтцэд голлох байр суурь эзэлсэн хэвээр байна. Гэвч түүхий эдийн олон улсын зах зээлийн үнэ буурсантай холбоотойгоор экспортын дундаж үнэ ихэнх бүтээгдэхүүнд буурсан нь нийт орлогод сөргөөр нөлөөлжээ.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай Улс дэлхийн 140 орноос гарал үүсэлтэй бараа импортолсноос БНХАУ-д 38.1 хувь; ОХУ-д 23.6 хувь; Японд 12.7 хувь; АНУ-д 4.1 хувь; БНСУ-д 4.3 хувь; ХБНГУ-д 2.5 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 85.4 хувийг эзэлжээ.

Нийт импортын 20.3 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 79.7 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлсэн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,124.5** сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 77.0 сая ам.доллараар буюу 6.4 хувиар буурсан.

Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **4,403.7** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 226.8 сая ам.доллар буюу 5.4 хувиар өссөн.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 6 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	484.0	1,008.9	1,201.5	1,124.5	-77.0	-6.4	20.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1,455.6	3,264.7	4,177.0	4,403.7	226.8	5.4	79.7
Нийт импорт	1,939.6	4,273.6	5,378.4	5,528.2	149.8	2.8	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги 22.2 хувь, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 20.6 хувь, эрдэс

бүтээгдэхүүн 20.3 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.8 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 7.7 хувийг тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Эхний 6 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2024	2025	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	66.5	69.4	3.0	4.5	1.3
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	104.1	89.0	-15.2	-14.6	1.6
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	18.6	25.3	6.7	35.8	0.5
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	382.4	425.4	43.0	11.2	7.7
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,201.5	1,124.5	-77.0	-6.4	20.3
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	279.0	310.3	31.4	11.2	5.6
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	178.8	185.4	6.6	3.7	3.4
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	4.5	4.3	-0.2	-4.9	0.1
9	Мод, модон эдлэл	49.9	60.3	10.4	20.9	1.1
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	40.1	36.8	-3.3	-8.2	0.7
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	63.8	55.6	-8.3	-13.0	1.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	18.3	19.6	1.3	7.0	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	113.8	119.2	5.4	4.7	2.2
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	2.2	2.3	0.1	4.5	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	463.2	487.3	24.1	5.2	8.8
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,130.7	1,137.2	6.5	0.6	20.6
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	1,127.0	1,229.0	102.0	9.1	22.2
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	63.9	75.4	11.5	18.0	1.4
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	68.9	69.8	0.9	1.2	1.3
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0	0.1	0.1	864.5	0.0
21	Бусад	1.2	2.1	0.9	70.7	0.0
	ДҮН	5,378.4	5,528.2	149.8	2.8	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортод голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүн

Суудлын автомашин импорт:

Тайлант хугацаанд суудлын автомашин 62,789 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,338 ширхэг буюу 9.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 3,048 ширхгээр, бусад суудлын автомашин 2,290 ширхгээр тус тус өссөн.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Барааны төрөл	Тоо хэмжээ		Өөрчлөлт		Татварын дүн		Өөрчлөлт	
	2024.06	2025.06	Дүн	Хувь	2024.04	2025.04	Дүн	Хувь
Хос тэжээлт	47,486	50,534	3,048	6.4	368.09	442.08	74	20.1
Бусад	9,965	12,255	2,290	23.0	152.04	230.54	79	51.6
Нийт	57,451	62,789	5,338	9.3	520.13	672.62	152	29.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлшний импорт:

Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж 2025 оны эхний 6 сард 1,230.9 мян.тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл	Барааны төрөл	Тоо хэмжээ /мян.тн/		Өөрчлөлт		Ногдуулсан татварын дүн		Өөрчлөлт	
		2024.06	2025.06	Дүн	Хувь	2024.04	2025.04	Дүн	Хувь
Автобензин	A-80	3.4	0.3	-3.1	-91.2	1.4	0.1	-1.3	-92.9
	A-92	411.1	391.2	-19.9	-4.8	111.1	108.1	-3.0	-2.7
	A-95 болон түүнээс дээш	12.0	7.5	-4.5	-37.5	8.7	5.1	-3.6	-41.4
Дизель түлш		781.3	831.9	50.6	6.5	316.0	309.2	-6.8	-2.2
Нийт		1,207.8	1,230.9	23.1	1.9	437.2	422.5	-14.7	-3.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 6 сард нийт 3,635.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,358.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 92.4 хувьтай байна. Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого 285.4 тэрбум төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 10. Татварын орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.06	2025.06		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Орлогын биелэлтийн хувь
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Хувь
Нийт орлого	3,072.8	3,635.9	3,358.2	285.4	9.3	92.4
Татварын дүн	2,995.5	3,557.7	3,284.4	288.9	9.6	92.3
Гаалийн албан татвар	814.9	1,014.7	899.5	84.6	10.4	112.8
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,802.6	2,182.7	1,950.0	147.4	8.2	111.9
Архи, дарсны онцгой албан татвар	27.2	30.3	29.5	2.3	8.5	102.7
Тамхины онцгой албан татвар	68.2	63.3	77.4	9.2	13.5	81.8
Шар айргийн онцгой албан татвар	4.8	5.2	9.3	4.5	93.8	55.9
Суудлын автомашины онцгой албан татвар	263.0	231.2	305.1	42.1	16.0	75.8
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	2.3	11.3	1.6	-0.7	-30.4	706.3
Автобензин, дизель түлшний албан татвар	12.5	19.0	12.0	-0.5	-4.0	158.3
Экспортын татвар	0.02	0.0	-	0.0	-100.0	-
Хураамж	71.4	67.2	65.1	-6.3	-8.8	103.2
Өөрийн орлого	5.9	11.0	8.7	2.8	47.5	126.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 285.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 147.4 тэрбум төгрөг;
 - Гаалийн албан татвар 84.6 тэрбум төгрөг;
 - Суудлын автомашины онцгой албан татвар 42.1 тэрбум төгрөг;
 - Тамхины онцгой албан татвар 9.2 тэрбум төгрөг
 - Шар айрагны онцгой албан татвар 4.5 тэрбум
- төгрөг
 - Өөрийн орлого 2.8 тэрбум төгрөг;
 - Архи, дарсны онцгой албан татвар 2.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин хураамжийн орлого 6.3 тэрбум төгрөг, автобензин, дизель түлшний онцгой албан татвар 0.7 тэрбум төгрөг, автобензин дизель түлшний албан татвар 0.5 тэрбум тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022-2025 онд баталсан тогтоолууд болон гурвалсан гэрээний дагуу дагуу **120.0 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулсан. Үүнд:

- **Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалын төслийг хэрэгжүүлэх**

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр “Нарийн сухайт эрчим” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **1.8 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийг хэрэгжүүлэх**

2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Эрдэнэс цагаан суварга” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **42.4 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр төслийг хэрэгжүүлэх**

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Цэнгазар” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **4.9 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Тосонцэнгэл дулааны цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх**

2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр “Тосон Энержи” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **0.9 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх**

2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр “Райд Монголиа” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **4.6 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Гэрэлт говь үйлдвэрлэл технологийн паркийн төсөл**

2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн гэрээгээр Си Өү Эй Эл ХХК-ний **15.1 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Бөөрөлжүүтийн 300МВт-ын цахилгаан станц**

2024 оны 09 дугаар сарын 19-ний өдөр “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **50.3 тэрбум** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн.

- **Багахангайн 660 Мвт цахилгаан станц**

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Касэн пауер грийн энержи” ХХК болон төрийн байгууллагууд хооронд гэрээ байгуулж, **47.6 сая** төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт тус тус хийсэн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС